

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Даваадорж	Дугаар	L222
Оршин суугаа аймаг	Архангай	Оршин суугаа сум	Эрдэнэбулган сум
Төрсөн газар	Эрдэнэбулган сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Заяын хүрээний музейн ажилтан, Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Заяын доод хүрээ	Сүм хийдийн дугаар	АРЭБ 052
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 3	Ярилцлага авсан хүн	Д.Мөнхбат

### Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Заяын доод хүрээ

Мөнхбат: Тэгэхлээр бид нар Сайн ноёнхан аймгийн бурхан номын томоохон газар, хүрээ хийдийн нэг Заяын Гэгээний хийдийн туурь, Заяын Гэгээний хүрээ хийдийн орчмоос энэ ярилцлагыг хийсэн юм. Бид нартай ярилцлага хийхээр Архангай аймгийн музейн эрхлэгч, 1966,67 оноос энэ музейд 40 гаруй жил ажиллаж байгаа манай музейн ахмад ажилтан Даваадорж гуайтай ярилцлагаа эхлэж байна. Танаас 2,3 зүйлийг асууя. Энэ аймгийн орон нутгийн судлах музейн байрлаж байгаа энэ Заяйн Гэгээний барилгад орох энэ орд сүм дуганууд тухайн үедээ Заяын Гэгээний сүм хийдийн ямар ямар нэр орд дуганууд байсан юм бол?

Даваадорж:

Манай Зая Бандид Гэгээний хүрээ хийд бол 400 гаруй жилийн түүхтэй ийм хүрээ хийд. Энэ хүрээ хийдэд бол 200 гаруй сүм хийд байсан. Түүнд 2214 лам нар шавилан сууж байсан. Монгол эрчүүдийн 40% нь эрдэмтэй хүн байсан гэж болно. Манай музей байгаа энэ цогцолбор гол цогцолбор нь, за дээд доод хүрээ гэж байсан, энэ бол дээд хүрээ нь байгаа юм. Энд бол анх Чонотын Хонхор гэж хонхор байсан, энд Заябандид Гэгээний Хийдийг байгуулахаар тохиролцож энд байгуулсан юм. Манай музей бол анх 1947 онд байгуулагдсан. Энэ Зая Бандид Гэгээний хийдэд 1965 оноос эхлэн үзмэр байрлуулсан. Үүнээс хойш нэг удаа их засвар хийсэн, их засвар хийснээс хойш 30-аад жил болж байна. Баруун зүүн талд нь лаврин гэж байгаа. Лаврингийн дээд талын 3 гүдэн орой нь бол байхгүй байсан бид шинээр бариулсан юм. За энэ Хөлийн сүм гээд энэ сүмийг 86 онд шинээр байгуулсан. Ингээд энүүхэн энд цогцолбор нь бүрдээд байгаа юм.

Мөнхбат:

Монголын Буддын Шашны түүхэнд том, тод мөр нэрээ үлдээсэн Заяын Гэгээний хүрээ дээр одоо шинэ цагийн Монголын орчин цагийн музейг түшиглэн байгуулаад ажиллаж байгаа таны хувьд, танай музейн сан хөмрөгт Заяын Гэгээний анхдугаар дүрээс эхлээд дараа дараачийн дүрүүдийн эдлэж хэрэглэж явсан бурхан шашны

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

холбогдолтой үзмэрүүд байгаа гэдэгт итгэж байна. Нууц биш бол, Монголд ганц хувь байдаг, Заяын Гэгээнүүдийн хэрэглэж явсан сонин содон эд хэрэгслэлүүдээс байвал товчхон хэлж өгнө үү.

Даваадорж:

Манай музей бол 10 000 гаруй үзмэртэй, улс аймагтаа 1-р байранд ордог ийм музей. Музейд улсад байхгүй 15 ширхэг үзмэр байдаг. Тэдний нэг нь зая Бандид Гэгээний үзмэрээс ордог. Энэ нь шүүсний 4 хос хутга байна мөн Зая бандид Гэгээний 14-хөн насандаа өмсөж байсан шаахай бий, энэ шаахай бол бас сонин хийцийн ийм шаахай байгаа. Үе үеийн Зая Бандидын, за манай Зая Бандид чинь 80 хасаг тэрэг ном уншисан маш их эрдэмтэй хүн байсан. Энэ Зая Бандид Гэгээнийхээ үзмэрүүдийг анх удаа 93 онд нээсэн, Зая Бандидын Музей гэж. Манайх бол нууцлаад байх юм байхгүй, хадгалалт хамгаалалт маш сайн, дохиололтой болсон, цагдаад холбогдсон. Ер нь хадгалалт хамгаалалт сайн болсон учраас нууцлаад байх юм байхгүй үзмэрүүд байж байгаа. За тэгээд 7-р Зая Бандид Гэгээнээ залсан сэнтий нь байж байна. Мөн 1, 2-р Зая Бандид Гэгээний гүдэн, шарил нь байгаа. Энэ бол бас ховор үзмэр. Өндөр гэгээн Занабазар гуай дорно дахинд бурханы урлал, тэр тусмаа эмэгтэй хүнийг гоо зүйн талаас нь урлаж маш их гайхагдаж байсан. Энэ Цагаан Шүхэрт гэдэг бурхан бол Очирхуяг дарханы хийсэн хийц хэлбэрийн хувьд бол нэлээд гайгүй хийцтэй ийм бурхан байгаа. Манайх бол үзмэрүүдээ өдөр нь тавиад оройн сейфэнд хийгээд цагдаа магдаа ийм газар хадгалуулдаг болсон. Тэгээд одоо тодорхой ярьж байгаа нь энэ. За энэ Зая Бандид Гэгээний шанз эсгий хөшиг байж байна, энэ бол маш их ховор үзмэр байгаа. Мөн Ерэнтэй дарханаас Зая Бандид Гэгээнд дурсгаж байсан зэсэн дээр мөнгөөр цардаж хийсэн домбо байж байна, луу ороож хийсэн. Энэ домбоны халууныг үдийн хугархай хадгалдагийг одоо хүртэл нууцыг нь олоогүй байгаа гэх мэтчилэнгийн үзмэрүүд манайд нэлээн байна.

Мөнхбат:

Энэ Зая Бандид Гэгээний, Заяийн хүрээний сүм дуганы бүрэн бүтэн байдал дээр түшиглэж байгуулсан тус аймгийн музейн үзмэрүүд одоо өнөөдөр гадаадын зочид гийчид, дотоодын зочид аялагчдын үзэх очих дуртай газруудын нэг гэдэг нь мэдээж. Та бүхэн Зая Бандид Гэгээний түүх дурсгалын үнэт үзмэрүүдээр дамжуулаад хойч үедээ болон гадаад дотоодынхонд Монголын түүх соёлын дурсгалыг сурталчлан таниулж байгаа нь мэдээж. Энд байгаа түүх соёлын хосгүй үнэт дурсгалууд ном судар мөн буддын шашны гайхамшиг болсон бурхан, шашны зан үйлд хэрэглэгддэг тэр эд хэрэглэгдэхүүнүүдыг судлаж шинжлэх ухааны эргэлтэнд оруулж судлаачдын өөрөөр хэлбэл угсаатны зүйн талаас, буддын соёл талаас, бурханы урлахуйн ухааны талаас нь судлаачдын анхаарлын төвд оруулах талаас нт шинжлэх ухааны эргэлтэнд оруулах талаас нь танай музей ямар бодлого баримтладаг вэ?

Даваадорж:

Манайд чинь сайхан ховордсон судрууд их бий. Ганжуур Данжуурын боть байж байна мөн угсаатны зүйн музейг улсад анх удаа нээсэн учир манайх чинь Төв Халхын Төв Музей больё гэж цаашдаа зорьж байгаа бүс нутгийн хувьд. Сая бас ЮНЕСКО-гоос хүмүүс ирлээ, фондыг тохижуулах талаар ярьж байна, аймгийн Засаг дарга Хүрэлсүх, МУ-ын Ерөнхийлөгч Энхбаяр даргыг Францад айлчлахад нь хамт яваад музейгээ засах талаар яриад,

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Алтангэрэл сайдтай яриад, сая бас зураг төслийг аваад явлаа, гэх мэтчилэн энийг сэргээн засварлах манай эрдэмтэд, гадаадын эрдэмтэд нар ирж маш их судалгаа хийсэн, зарим хариу нь ирж байна, зарим нь ирээгүй байна. Одоо энэ гадаа байгаа хөшөө л гэхэд 528 онд хийсэн хөшөө Киргиз Киданы үеийн хөшөө эртний, Их Тамир сумын Хөх Нуур гэдэг газраас олдсон ийм хөшөө, энэний бичээс гэвэл тайлагдсан гэх мэтчилэнгийн ийм ховор юмнууд бол байна хойшдоо гадаад дотоодын улсуудтай хамтарч ажиллана. Энэ жил гадаадад үзэсгэлэнд явахаар 3 үзмэр шалгарч тэнд үлдээд Улаанбаатарт байгаа. Эдгээр ажлуудыг нэлээд зохион байгуулж байна.

Мөнхбат:

За танд баярлалаа. Төрж өссөн нутагтаа 40 жил Заяын Гэгээн гэх тэр агуу хүний оюун бодлын орчлон болсон энэ их бурхан номын оронтой амьдралаа холбож, бурхан шашны ном судар, зан үйлийн эд өлгийг нь хадгалан хамгаалж, гадаад дотоодод сурталчлах, хойч үедээ сурталчлан таниулах энэ буянтай ажилд тань амжилт хүсье.